

СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ӨНӨӨДӨР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗАРИМ АНГИУДАД АЖИЛЛАЖ БАЙНА

Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Зэвсэгт хүчний ангиудад ажиллаж байгаа билээ. Өнөөдөр Сонгино цэргийн хүрээний Зэвсэгт хүчний 013, 017, 150 дугаар ангиудад ажиллаж байна. Тэрээр ангид ажиллах хугацаандаа бие бүрэлдэхүүнд ойрын хугацаанд салбарын хэмжээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл өгч, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгч ажиллаж байгаа юм.

Батлан хамгаалахын сайдыг дагалдан БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба, Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал ГХАГ-ын дарга, хурандаа



ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 26	🌧️ 13
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 32	🌧️ 22
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	🌧️ 17

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.844.00	2.855.00
EUR 🇪🇺	3.451.00	3.510.00
CNY 🇨🇳	444.50	448.40
RUB 🇷🇺	38.40	40.00
JPY 🇯🇵	25.71	26.20
KRW 🇰🇷	2.48	2.62

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 24
2021.06.04.
/БААСАН ГАРАГ/
**ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН
МОГОЙ САРЫН ЗУРГААН
ЦАГААН ХАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

Үс засуулбал:
Өвчин эмгэг ирнэ.
Наран ургах, шингэх:
04.55-20.46
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Сансар
Суудал:
Огторгуй.
Аргын тооллын 6 сарын 4, Сугар гараг. Билгийн тооллын давхарласан 24, Могойг хүлэгч одтой, харагчин хонь өдөр. Өдрийн наран 4 цаг 55 минутад мандан, 20 цаг 46 минутад жаргана. Тухайн өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Сахил санваар авах, хануур төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ТӨГСГӨЛИЙН ШАТНЫ ХУРАЛ БОЛЛОО

АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦ 90 КМ ЗАМ ТУУЛААД БАЙНА



Ховд аймгийн Буянт сумын харьяат, Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц Ховд хотоос Улаанбаатар хот хүртэл 1500 км зайд гүйхээр 6 дугаар сарын 2-ны өдөр гараанаас гарсан. Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгтгэл, анги салбараас анх удаа холын зайд гүйхээр эр зориг, түүхэн шийдвэр гаргасан Э.Даваажамцыг Ховд аймгийн Засаг дарга, Баруун бүсийн ангийн удирдлага, бие бүрэлдэхүүн, Цагдаагийн газрын удирдлага, хамт олны төлөөлөл, найз нөхөд, ар гэрийнхэн нь амжилт хүсэж, аймгийн төв талбайгаас үдэн гаргасан юм. Тэрээр өдөрт 45-50 км гүйхээр төлөвлөсөн ба өнөөдрийн байдлаар /09.00 цагт/ Ховд аймгийн Манхан сумаас гараад Зэрэг сум орж яваа бөгөөд 90 км зам туулаад байгаа юм.



“АрМИ” олон улсын цэргийн наадмын Аравт морин цэргийн уралдаан, Цэргийн ралли тэмцээнийг зохион байгуулах асуудлаар төгсгөлийн шатны төлөвлөлтийн цахим хурал өгчигдөр болов. Хуралд 11 улсын төлөөлөгч оролцож, өөрийн нутагт явагдах тэмцээн уралдааны талаар санал солилцож, зарим асуудлыг тодотгосон бөгөөд ОХУ-ын талаас олон улсын цэргийн наадмын талаар товч мэдээлэл хийсэн. Одоогийн байдлаар тэмцээнийг зохион байгуулах улсууд бэлтгэл ажлаа 65-70 хувьтай гүйцэтгээд байна. Монголын талыг төлөөлөн ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын

генерал С.Дашзэвэг тэргүүтэй албаныхан оролцож, Цэргийн ралли, Аравт морин цэргийн уралдааны бэлтгэл, ажлын явц, хөтөлбөр төлөвлөгөө, халдвар хамгааллын дэглэмийг танилцуулав. Долоо дахь удаагаа зохион байгуулагдах гэж байгаа цэргийн наадам нь 12 улсын нутагт явагдах юм. Нийт 34 төрлийн тэмцээнд 41 улсын 277 баг оролцохоо мэдэгджээ. Энэ жил Хятад, Узбекистан, Беларусь, Вьетнам улсаас хамгийн олон баг оролцож байна. Хурлаар мөн тэмцээн явагдах газар орон, журам, ар талын хангалт, ирэх жилийн тэмцээний хэтийн төлөв зэрэг асуудлыг хэлэлцжээ.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
61.396	51.983	288/14

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
2629 (36)	271	2320

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол	Нийт: 170,812,850
Эдгэрсэн	Нийт: 148,348,215
Нас барсан	Нийт: 3,557,586

ТАНДАЛТ

ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	25,741 2,495,568
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	8,133 2,858,085
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	1,234 409,180
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН	НИЙТ
СҮҮЛИЙН 24 ЦАГТ	639 77,570

2021.05.20
11:00 УТГАА БАЙДАГ

ҮЙЛ ЯВДАЛ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БҮРЭЛДЭХҮҮНД УГИЙН БИЧИГ ХӨТЛҮҮЛЭХЭД АНХААРАХ ТУХАЙ ЯРИЛАА



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай өчигдөр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал, анги, салбаруудын бие бүрэлдэхүүнд гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжил, төлөвшил, залуучуудын хөгжил, нийгэм хамгаалал гэсэн сэдвүүдээр сургалт, уулзалтуудыг хамтран зохион байгуулах ба нөгөө талаас хүүхэд багачуудыг цэрэг-эх оронч үзэл, хүмүүжлээр төлөвшүүлэх юм байна. Санамж бичигт Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, хошууч генерал

О.Энхбаяр, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Ө.Ган-Өлзий нар гарын үсэг зурсны дараа хамтын ажиллагаагаа хэрэгжүүлэх арга хэлбэрүүд, сургалт уулзалтуудыг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан хэрхэн зохион байгуулах талаар санал солилцсон юм. Хошууч генерал О.Энхбаяр “Зэвсэгт хүчин гэдэг нийгмийн маш том салбар. Том салбар учраас олон залуу гэр бүл, хүүхэд багачуудын хүмүүжил, төлөвшил, залуучуудын хөгжлийн тухай яригдахаас аргагүй. Бид “Цэргийн хүн ахлах даргын өгсөн үүргийг мадаггүй биелүүлэх ёстой” гэж үүрэг өгөхөөс биш тухайн хүний амьдрал, гэр бүл рүү

хандсан ажил, арга хэмжээг төдийлөн анхаараагүй байна. Манай Агаарын цэргийн алба хаагчдын зарим нь хотын төвд, зарим нь шувуунаас ч өөр хангуй гэмээр алслагдмал газар алба хааж байна. Тэдэнд чиглэсэн сургалтад хамтран ажиллахад бид бэлэн байна” гэсэн юм. Үүний дараа Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Ө.Ган-Өлзий сүүлийн үед ЗХЖШ-тай хамтран хэрэгжүүлсэн ажлуудынхаа талаар танилцуулаад төлөвлөгөөт сургалт, нөлөөллөөс гадна угийн бичиг хөтлөх ажлыг Зэвсэгт хүчний Агаарын цэргээр хязгаарлагдахгүйгээр нийт бие бүрэлдэхүүнээр мөрдүүлэхэд анхаарч буйгаа уламжлав.

БХЭШХ-ЭЭС ШИНЖЛЭХ УХААНЫ ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ТӨРЛӨӨ



“Оюутан цэрэг” сургалтын ерөнхий зохицуулагч, Монгол Улсын Гавьяат багш, Шинжлэх ухааны доктор, профессор, бэлтгэл хурандаа Гэрэлийн Мягмаржав Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2021 оны 6 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын “Ардын багш”, Шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал Одохүүгийн Үржинд Монгол Улсын “Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн” цол хүртээлээ.

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ БАЙНА



Хэнтий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Хэнтий аймагт коронавируст цар тахал /Covid-19/-ын халдварын голомт үүсэж өвчлөл нэмэгдсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой комиссоос гарсан Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг шилжүүлэх, хорио цээрийн дэглэмд шилжүүлэх тухай шийдвэрийг хэрэгжүүлэх үүднээс цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаагчид Онцгой байдлын газар, Цагдаагийн алба хаагчидтай хамтран 4 дүгээр 16-ны

өдрөөс эхлэн 1 сарын хугацаанд аймгийн төв Чингис хот болон сумдын хяналтын цэгүүдэд иргэд болон авто машины хөдөлгөөнд хяналт тавьж ажиллалаа. Мөн хот тохижилт, үйлчилгээний газартай хамтран Чингис хотын эргэн тойрны 10 тонн хур хогийг цэвэрлэх, ногоон байгууламжийг сэргээн сайжруулах, хаврын хуурайшилттай холбогдуулан өнжмөл өвс шатаах, аймгийн Улаан загалмайн хорооны хүнс татан авалт, иргэдэд тараах зэрэг ажилд хамтран оролцож, дэмжлэг үзүүлээ.

ДУГУЙН СПОРТООР ХИЧЭЭЛЛЭДЭГ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД НЭГДЖЭЭ



НҮБ-аас жил бүрийн 6 дугаар сарын 3-ны өдрийг “Дэлхийн унадаг дугуйн өдөр” хэмээн зарласан билээ. Дугуйн өдөр хэмээн онцолсны учир нь “Хүн төрөлхтөн хоёр зуун жилийн

турш хэрэглэж ирсэн унадаг дугуй нь өөрийн гэсэн өвөрмөц шийдэлтэй, урт удаан ашиглахуйц, олон талыг дэмжсэн, энгийн, хямд, найдвартай, эко, байгаль орчинд ээлтэй тогтвортой тээврийн

хэрэгсэл юм” гэж тодотгожээ. Тэгвэл бие бялдар, эрүүл мэндийн бэлтгэлтэй дэмжиж, байгаль эх дэлхийгээ хайрлаж, эко орчныг бүрдүүлэхэд гар бие оролцохоор ЗХЖШ-ын БСТГ-ын туслах мэргэжилтэн, сургагч ахлагч С.Цэнгэл, Хүний нөөцийн хэлтсийн хэрэг хөтлөгч, сургагч ахлагч Б.Энхбаяр, хүний нөөцийн мэргэжилтэн, сургагч ахлагч Б.Ганбат, ҮБХИС-ийн Батлан хамгаалахын Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн Мэргэшүүлэх сургалтын тэнхимийн дарга, тэргүүн ахлагч Ч.Мөнхтайван тэргүүтэй дугуйн спортоор хичээллэгч цэргийн алба хаагчид “E level” хэмээх баг байгуулжээ. Тэд дугуйн спортыг Зэвсэгт хүчний алба хаагчдад сурталчилж, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж хэвхийг уриалах зорилготой юм байна. Ингэхдээ өглөө бүр хамтдаа 20-30 км замыг, амралтын өдрүүдэд 80-120 км замыг дугуйгаар туулдаг байна. Зарим үед нийгмийн харууцлагын хүрээнд Туул голын ай сав орчмыг цэвэрлэж, олон нийтийн сайн үйлсийн аянд идэвхтэй оролцож, цэргийн албыг нийгэмд сурталчлахад өөрсдийн үйлдлээрээ үлгэрлэж байгаа ажээ.

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЦЭРГИЙН БАГ ҮҮРГЭЭ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨӨД, ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ



ИБНАУ-д явагдаж буй “Умард Атлантын Гэрээний Байгууллага”-ын тэргүүлсэн “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагааг дуусгавар болгож, тус улсаас эвслийн цэргийг 2021 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн дотор татан гаргах шийдвэрийг АНУ болон “Умард Атлантын Гэрээний Байгууллага”-ын гишүүн орнууд гаргаж, эвслийн цэргийг татан гаргах ажиллагаа 2021 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн явагдаж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн баг эвслийн цэргийн “Шинэ Кабул Бааз”-ын аюулгүй байдлыг хангах үүргийг

Дани Улсын цэргийн алба хаагчдад 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр хүлээлгэн өгч, эвслийн цэргийн нисэх хүчний “Баграм Бааз”-д шилжин байрласан.

Эвслийн цэргийн “Шинэ Кабул Бааз”-ыг Афганистаны үндэсний батлан хамгаалах аюулгүй байдлын хүчинд хүлээлгэн өгөх ёслолын ажиллагаа 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдөр явагдаж, баазад үүрэг гүйцэтгэж байсан цэргийн багууд өөрийн улсын төрийн далбааг буулгах, ИБНАУ-ын төрийн далбааг мандуулах ёслолын арга хэмжээ зохион байгуулагдсан бөгөөд Монгол Улсын

Зэвсэгт хүчний цэргийн багийн захирагч, дэд хурандаа М.Түвшинжаргал, цэргийн багийн холбогдох бүрэлдэхүүний хамт энэхүү арга хэмжээнд оролцлоо.


Ёслолын арга хэмжээнд ИБНАУ-ын Батлан хамгаалахын орлогч сайд, “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагааны хүчний командлагч генерал Аустин Скотт Миллер, Кабулын Аюулгүй байдлын хүчний командлагч бригадын генерал Олли Браун болон эвслийн цэргийн “Шинэ Кабул Бааз”-д үүрэг гүйцэтгэж байсан цэргийн багуудын удирдлага, албаны хүмүүс, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцсон юм.

Шийдвэртэй дэмжлэг” ажиллагааны хүчний командлагч генерал Аустин Скотт Миллер ёслолын ажиллагаанд оролцсоны дараагаар Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн захирагч дэд хурандаа М.Түвшинжаргалтай уулзаж, Монгол цэрэг “Шинэ Кабул Бааз”-ын аюулгүй байдлыг хангах үүргийг маш сайн гүйцэтгэн Афганистаны үндэсний батлан хамгаалах аюулгүй байдлын хүчинд амжилттай хүлээлгэн өгч, эх орондоо буцаж байгаад талархлаа илэрхийлж, амжилт хүслээ.

Ийнхүү Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багууд АНУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран ИБНАУ-д явагдсан “Умард Атлантын Гэрээний Байгууллага”-ын тэргүүлсэн “Шийдвэртэй дэмжлэг ажиллагаанд 17 жил тасралтгүй үүргээ амжилттай гүйцэтгэж, дэд хурандаа М.Түвшинжаргал захирагчтай цэргийн баг эх орондоо үүргээ амжилттай гүйцэтгээд ирээд байна.

Хошууч М.ТҮМЭНЖАРГАЛ

ЦАХИМ ТОГЛОЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



ҮБХИС

ҮБХИС-ийн Цэргийн хөгжмийн коллежийн мэргэжлийн боловсролын тэнхимийн сурагчдын тоглолт цахимаар явагдлаа. Цар тахалтай байгаа энэ хүнд үед тус сургуулийн багш нар сурагчидтайгаа цахим орчноор хичээл сургалтаа зохих түвшинд явуулж, үр дүнгээ бусдад танилцуулаад байна. Цахимаар зохион байгуулагдсан тус тоглолтод хөгжимдөх ур чадварын мэргэжлийн 11 багш өөрсдийн шавь болох 35 сурагчийг удирдан 20 гаруй бүтээлийг хөгжимдлөө. Хийл, саксофон хөгжмийн цөөхүүл чуулгыг Х.Ариунсайхан, Дмитро Таган нар удирдан оролцсон нь алсын зайнаас хамтран хөгжимдөх арга барилд сургах, сурах боломжийг харууллаа.